

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИУДЫН ТУРШЛАГА, МОНГОЛ УЛСЫН ХУВЬД ХАРГАЛЗАН ҮЗЭХ АСУУДЛУУД

С.Галбадрах /доктор Ph.D., дэд проф./ Д.Хөгжмаа /МА/
ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль
E-mail: galaa5@yahoo.com

Хураангуй.

Улс орны боловсролын ноён оргил нь судалгааны их сургууль байдаг. Дэлхийн улс орнууд шинжлэх ухаан, дэвшилтэт технологийг хөгжүүлж, мэдлэгийн эдийн засгийг бий болгох гол хөдөлгөөгч хүч нь судалгааны их сургууль хэмээн үзэж түүнийг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч байна. Энэхүү өгүүлэлд судалгааны их сургуулиудын хөгжлийн замнал, улс орнуудын судалгааны их сургуулийг байгуулж хөгжүүлсэн туршлагыг судлан үзэв. Мөн Монгол улсын тэргүүлэх зарим их сургуулийн үзүүлэлтүүдийг дэлхийн түвшний их сургуулиудтай харьцуулан, цаашид Монгол улсад судалгааны их сургуулийг байгуулах зарим тулгамдсан асуудлын талаар авч үзэв.

Түлхүүр үгс: инновацийн менежмент, судалгаа хөгжил, энтрепренершип, хамтын ажиллагаа ба түншлэл, дэлхийн түвшний их сургууль

Судалгааны их сургуулиудын байгуулагдсан түүх

Судалгааны их сургуулийн эхлэл XIX зуунд тухайлбал В.Хумбольдтийн байгуулсан Берлиний их сургуулиас эхлэлтэй. Энэ үед их сургуулиуд хууль анагаах ухаан, шашны салбарын мэргэжилтэн бэлтгэх үүрэгтэй байв. Берлиний их сургуулийн загвар нь судалгаанд зохицсон, судалгааны үр дүнгээ үндэсний хөгжилд зориулдаг байсан ба судалгааны загвартай зэрэгцээд хими, физик мөн эдийн засаг, социологи зэрэг нийгмийн шинжлэх ухааны салбарын бүтэц гарч ирсэн юм. Нэг үгээр хэлбэл, их сургуулийг улс төр нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр зориудаар уялдуулан холбож өгсөн юм [1].

АНУ-ын хувьд авч үзэхэд их сургуулиудыг дэмжих зорилгоор муж бүрт холбооны Засгийн газраас газар нутаг олгох тухай 1862 онд гарсан. Моррилын хууль нь ХАА, механикжуулалтын чиглэлээр их сургуулиуд нь мэргэжилтэн бэлтгэх, туршилт судалгааны ажлыг явуулахад том түлхэц үзүүлсэн. Ийнхүү дэмжлэг бүхий их сургуулиуд нь АНУ-ын ХАА-г дэлхийд тэргүүлэх байр суурь эзлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан [3]. Эдгээр нь хагас судалгааны их сургууль буюу АНУ-ын судалгааны их сургуулиудын эхлэл байв.

XX зууны дунд үе гэхэд АНУ-ын судалгааны их сургуулиуд дэлхийд тэргүүлэх загвар их сургууль болсон байв. Төрөөс судалгааны ажилд их хэмжээний санхүүжилт авч, судалгааг чухалчлан сургалтын системээ өөрчилж хүчирхэг, ашгийн

бус эрдэм шинжилгээ, сургалтын салбарыг хослуулснаар АНУ-ын их сургуулид олон улсад “шилдэг стандарт” болж чадсан байна [1]. Дэлхийн II дайнаас хойшхи буюу 1950 оноос хойшхи АНУ-ын шинжлэх ухаан, технологийн систем ба нийгэмд судалгааны их сургуулиудын гүйцэтгэх үүргээр нь 1950-1975 ба 1975 оноос хойшхи үе хоёр үе шатанд хувааж үзэж болно. Эхний үе шатанд судалгааны их сургуулиуд хөгжин улс орны шинжлэх ухаан, технологийн системийн цөм болсон бол хоёрдахь үе шатанд судалгаа шинжилгээний ажил дахь Засгийн газрын ба аж үйлдвэрийн санхүүжилтийн хувь нэмэр тасралтгүй нэмэгдэн дэлхий дахинд АНУ-ын судалгааны их сургуулиуд загвар болтлоо хөгжсөн байна. Тухайлбал, 1975 оноос хойш АНУ-ын судалгааны их сургуулиудын Нобелийн шагнал хүртсэн эрдэмтдийн тоо дэлхийн бусад орны эрдэмтдийг нийлүүлснээс хамаагүй их байна [6].

Дэлхийн олон улс орнуудад энэхүү ойлголт 1970-аад оны үеэс яригдаж эхэлсэн бөгөөд 1990-ээд оны үеэс улам эрчимжиж, улмаар олон сургууль сургалтад суурилсан үйл ажиллагаанаас судалгаанд суурилсан чиглэлээр хөгжлийн концепцоо тодорхойлж, 2000-аад оны эхэн гэхэд судалгааны их сургуулийг жинхэнэ утгаар нь бий болгож чаджээ.

Судалгааны их сургуулиудыг хөгжүүлж буй чиг хандлага

Мянганы хөгжлийн зорилтод хүрэхийн тулд шинэ дэвшилтэт мэдлэгийн хэрэглээг бий болгох, чадварлаг мэргэшсэн мэргэжилтэнүүдийг бэлтгэх асуудал чухал байр суурь эзэлнэ. Энэ үйл ажиллагаанд дээд боловсролын тогтолцоо, ялангуяа судалгааны их сургуулиудын үүрэг ач холбогдол өндөр юм. Ж.Салмигийн (2009) үзсэнээр аль ч их сургуулийг дэлхийн түвшний статустай болгоход нөлөөлдөг гурван үндсэн нөхцөл бий. Үүнд:

1. Авъяас чадвартай судлаачдыг татах
2. Санхүүгийн хангалттай нөөц, сургалт судалгааны орчин
3. Менежментийн тогтолцоо

Ж.Салми “Дэлхийн чансаатай их сургууль байгуулах нь” номондоо дэлхийн түвшний их сургуулийг байгуулах 3 үндсэн санааг гаргасан. Үүнд:

- Одоо үйл ажиллагаа явуулж байгаа чадавхитай цөөн их сургуулиудын үйл ажиллагааг

сайжруулах (сонгон шалгаруулах замаар)

- Зарим сургуулиудыг нэгтгэж шинэ загварын их сургууль болгон сайжруулах (Гибрид томъёолол)

- Засгийн газраас шинээр байгуулах (шинэ дэвшилтэт арга)

Дэлхийн улс орнууд судалгааны их сургуулиудыг байгуулахдаа эдгээр арга замуудаар хэрэгжүүлж буй болно. Гэхдээ ихэнх тохиолдолд эхний 2 арга замыг түгээмэл сонгож буй болно.

Эдийн засгаа хурдацтай хөгжүүлж байгаа улс орнууд даяарчлалын эрин үед их сургуулиудаа идэвхийлэн хөгжүүлэх болсон. Хэдэн зууныг дамнан байж сая нэг дэлхийн шилдэг их сургуулийн нэгэнд багтах бус харьцангуй богино хугацаа зарцуулж болохыг олон улс орны жишээнээс харж болно. Тиймээс улс орнууд үндэсний тэргүүлэх их сургуулиудынхаа эрдэм шинжилгээ, судалгааны хүчин чадлыг бэхжүүлж сайжруулахын сацуу шинэ тутам судалгааны их сургуулиудыг байгуулах болсон.

БНХАУ дэлхийн түвшний их сургуулиудыг байгуулах талаар хамгийн амжилт олж байгаа улс орон юм. Дэлхийн түвшний их сургуулиудыг байгуулах үйл ажиллагаа нь БНХАУ-ын Боловсролын яамнаас “211 төсөл”, “985 төсөл”-үүдийн санаачлан хэрэгжүүлснээр эхэлсэн юм [1]. 1995 онд боловсруулсан “211 төсөл” нь XXI зууны эхний хагаст улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд тэргүүлэх чиглэлтэй, олон улсад өрсөлдөх чадвартай 100 их сургуулийг хөгжүүлэх явдал байсан. Уг үндэсний санаачилга нь салбар дундын хөтөлбөр, дижитал хотхон, боловсон хүчин, их сургуулийн дэд бүтэц гэсэн дөрвөн үндсэн чиглэлд төвлөрсөн. 1998 онд “XXI зууны Боловсролын шинэчлэлийн хөтөлбөр”-ийг баталж шилдэг их сургууль, судалгааны төвүүдийг (39 их сургууль) байгуулахаар “985 төсөл”-д тусгагджээ. Уг төсөл нь 39 их сургуулийг дэмжих хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн ба шинэчлэл нь их сургуулийн удирдлага, менежмент, хүний нөөцийн чадавхийг үе шаттайгаар хөгжүүлсэн. Дээрх төслүүдийг хэрэгжүүлснээр Бээжингийн их сургууль, Цинхуа их сургуулиуд тус бүр 1,8 тэрбум юань буюу 225 сая доллар авсан бол бусад их сургуулиуд 400 сая юаниас 1,4 тэрбум хүртэл юанийг тус тус авчээ [8]. Жишээ болгон дурдахад Шанхайн Жяо Тун их сургуулийн хувьд нийт төсөв нь сүүлийн 10 жилд 4 дахин өсчээ. Жяо Тун их сургуулийн орлогын 20%-ийг Засгийн газрын тогтмол санхүүжилтээс, 20% нь “985 төсөл”, “211 төсөл” зэрэг Засгийн газрын санаачилсан тусгай санхүүжилтээс, 30% нь судалгааны орлогоос, 20% нь сургалтын төлбөрөөс, 10% нь бусад эх үүсвэр, түүний дотор хандив, их дээд сургуулиудын харъяа аж ахуйн нэгжийн орлогоос тус тус бүрддэг байна [1].

“211 төсөл”, “985 төсөл”-үүд хэрэгжсэнээр Times Higher Education байгууллагын Дэлхийн шилдэг их сургуулиудын тоонд багтах сургуулиудыг олноор нэмэгдүүлж чадсан бөгөөд ойрын 30 жилд дэлхийн шилдэгт багтах их сургуулиудын тоог 2

дахин нэмэх зорилт дэвшүүлсэн байна [9].

Дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн их сургуулиудын рейтингийг тогтоодог 3 байгууллагын (QS World University Ranking, Times Higher Education, Academic Ranking of World Universities) аргачлалыг харьцуулан авч үзье [14].

QS World University Ranking нь судалгаа шинжилгээ, багшлах боловсон хүчин, сургалт, глобалчлагдсан байдал зэрэг 6 үзүүлэлтээр зэрэглэл тогтоодог. Тухайн их сургууль нь ахисан түвшин ба төгсөлтийн дараахь сургалттай байх, хамгийн багадаа таван салбараас хоёрыг хамарч үйл ажиллагаа явуулах шаардлагыг тавьдаг байна (Үүнд, хүмүүнлэг ба урлаг, инженер ба технологи, нийгмийн ухаан ба менежмент, байгалийн шинжлэл, ХАА ба анагаах). Үүнд:

- Академик нэр хүнд (нийт онооны 40%)-глобал академик судалгааны нэр хүнд
- Төгсөгчдийн нэр хүнд (10%)-тухайн салбартаа манлайлан ажиллаж байгаа төгсөгчдийн нэр хүнд
- Багш-оюутны харьцаа (20%)-өндөр чанарын сургалт зөвлөгөө
- Багшид ногдох эшлэл (20%)- байгууллагын судалгааны цар хүрээ
- Гадаад багшийн харьцаа (5%)-гадаад багшийг ажиллуулж буй байдал
- Гадаад оюутны харьцаа (5%) гадаад оюутныг суралцуулж буй байдал

Times Higher Education нь 5 төрөлд 13 шалгуур үзүүлэлтээр зэрэглэл тогтоодог. Үүнд:

- Сургалт (30%)- нэр хүндийн судалгаа (15%), багш оюутны харьцаа (4.5%), бакалавр, докторын суралцагчдын харьцаа (2.25%), докторын зэрэг хамгаалсан төгсөгчдийн харьцаа (6%), байгууллагын орлого (2.25%)
- Судалгаа (30%)- нэр хүндийн судалгаа (18%), судалгааны ажлын орлого /багш нарын тоо ба хэвийн худалдан авах чадварын тэнцвэрт байдлын харьцаа/ (6%), багшид ногдох өндөр рейтингтэй сэтгүүлд хэвлэсэн өгүүллийн тоо (6%)
- Судалгааны ажлын эшлэл (30%)
- Олон улсын үр нөлөө (7.5%)-гадаад оюутны харьцаа (2.5%), гадаад багшийн харьцаа (2.5%), олон улсын хамтарсан судалгаа (2.5%)
- Үйлдвэрлэлийн орлого (2.5%)-үйлдвэрлэлээс олох орлого ба багшийн тоо хэвийн худалдан авах чадварын тэнцвэрт байдлын харьцаа

Шанхайн Жяо Тун их сургуулиас гаргадаг Academic Ranking of World Universities (ARWU) 6 үзүүлэлтээр зэрэглэл тогтоодог ба эдгээр нь судалгааг нэн тэргүүнд тавьдаг. Үүнд:

- Боловсролын чанар (10%)- Төгсөгчдөөс Нобелийн шагнал, салбарт нээлт хийсэн Фейлдсийн шагнал хүртсэн байдал
- Шагналууд (20%)- Төгсөгчдөөс Нобелийн шагнал, салбарт нээлт хийсэн Фейлдсийн шагнал хүртсэн байдал, 21 салбар судлагдахууны хүрээнд өндөр эшлэлтэй судалгааны ажил

- Өндөр эшлэлтэй судалгаанууд (20%)-Thomson Reuters-ийн индекстэй бүтээлийн эшлэлийн индекс
- Байгалийн шинжлэлийн индекс (20%)-Nature and Science сэтгүүлүүдэд 4 жилийн хугацаанд хэвлэгдсэн өгүүлүүд
- Индекстэй өгүүлүүд (20%)-Science citation index ба Social science index-д өмнөх жил хэвлүүлсэн өгүүлүүд
- Нэг хүнд ногдох гүйцэтгэл (10%)-Дээрх 5 шалгуур үзүүлэлтийн нийлбэрийг тухайн сургуулийн багш, эрдэмтдийн тоонд хуваана.

2020 оны байдлаар дээрх байгууллагуудын зэрэглэлээр дэлхийд чансаагаар эхний 1000-д орсон сургуулиудыг судалгааны их сургуулиуд гэж тооцож болно. Учир нь эдгээр байгууллагуудын их сургуулиудын зэрэглэл тогтоох үзүүлэлтийн 60-аас 100 хүртэлх хувь нь зөвхөн дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны үзүүлэлтүүд байдаг байна. Дээрх байгууллагуудын зэрэглэлээр өндөр чансаатай их сургуулиудын тоогоор тэргүүлж буй улс орнуудыг авч үзвэл:

- Times Higher Education байгууллагын зэрэглэлээр хамгийн олон сургууль нь эхний 1000 сургуульд багтсан бүхий улс орнуудыг жагсаавал АНУ 167, БНХАУ 75, Англи 72, Герман 48, Итали 45, Япон 43, Испани 40, Австрали 35, Франц 36, Энэтхэг 36, Канад 29, БНСУ 24, ОХУ 15, Нидерланд 13 байна.
- QS World University Ranking зэрэглэлээр хамгийн олон сургууль нь эхний 1000 сургуульд багтсан бүхий улс орнуудыг жагсаавал АНУ 157, Англи 84, БНХАУ 50, Герман 46, Япон 41, Итали 34, БНСУ 30, Испани 27, Австрали 35, Франц 31, ОХУ 25, Энэтхэг 24, Канад 26, Нидерланд 13 байна.

- Academic Ranking of World Universities зэрэглэлээр хамгийн олон сургууль нь эхний 1000 сургуульд багтсан бүхий улс орнуудыг жагсаавал АНУ 206, БНХАУ 168, Англи 65, Герман 49, Итали 46, Япон 40, Испани 40, Австрали 34, БНСУ 32, Франц 30, Канад 28, Энэтхэг 15, Нидерланд 13, ОХУ 11 байна.

Дээрхээс үзэхэд өндөр хөгжилтэй улс орнуудын их сургуулиуд дэлхийд чансаагаараа тэргүүлж байгаа бөгөөд БНХАУ, Япон, БНСУ, Энэтхэгийн их сургуулиуд Ази тивд төдийгүй дэлхийн түвшинд баттай байр суурь эзлэх болсон байна.

Ж. Салмигийн (2009) боловсруулсан гурван хүчин зүйл бүхий (авъяас чадвар, хөрөнгө санхүүжилт, удирдлагын тогтолцоо) бүхий загвар нь хүлээн зөвшөөрөгдсөн загвар хэдий ч мөн судалгаагаар зарим хүчин зүйлсийг өргөтгөн авч үзсэн болно. Судалгааны их сургуулийг хөгжүүлэхийн тулд академик системдээ чиг үүргийн хуваарийг тодорхой болгох шаардлагатай ба профессоруудын мэдэлд байх; гол шийдвэрийг багш судлаачдын саналд үндэслэн гаргадаг байх; мерит систем бүрэн хэрэгжсэн; судалгаа сургалт нягт холбоотой; эрдмийн эрх чөлөө; нийгэмд үйлчилдэг байхыг чухалчлан авч үзсэн [7]. Судалгааны их сургуулийн шийдэх үндсэн асуудал – нийгэм, эрдмийн ертөнцтэй холбоо харилцаа тогтоох, хэвлэл, номын сан, эрдэмтдийн нийгэмлэг, эрдмийн чуулган, мэргэжлийн холбоо, интернет, мэдлэгийн сан [5] чухал байна.

Монгол улсын зарим их сургуулиудыг дэлхийн түвшний сургуулиудтай харьцуулах нь

МУИС, ШУТИС-ийн зарим үзүүлэлтүүдийг тив бүрийн төлөөлөл болох судалгааны их сургуулиудтай харьцуулан Хүснэгт-1 –д харуулав.

Их сургуулиуд, байгуулагдсан он	Суралцагчдын тоо	Оюутан /багшийн харьцаа/	Хандив /ам. доллар/	Жил бүрийн төсөв /ам. доллар/	1 оюутанд ногдох зардал /ам.доллар/
Ибаданы ИС (1962)	19521	16:1	0,2 сая	43 сая	46700
Шанхай Жяо Тун ИС (1896)	14000	15:1	120 сая	700 сая	16300
Пуханы ИС(1987)	3100	6:1	2 тэрбум	220 сая	70000
Чилийн ИС (1842)	30702	15:1		520 сая	17000
Чилийн Католик санваартны ИС(1888)	22035	8:1		453 сая	20500
Бомбейн Технологийн институт (1950)	28000	8:1		123 сая	4400
Хонконгийн ШУТИС (1991)	9271	19:1	0.25 сая	267 сая	28850
Малайн ИС(1949)	26963	12:1		271 сая	14000
Сингапурын ИС(1980)	27396	14:1	1 тэрбум	1.37 тэрбум	39000
Монтеррей ИС(1943)	25705	12:1	1 тэрбум	1.15 тэрбум	10200
ЭЗДС (1992) ОХУ	16000			45.5 сая	2843
МУИС (1942)	17712	19:1		53,5 тэрбум төгрөг= 18.5 сая доллар	1044
ШУТИС (1959)	17187	17:1		57 тэрбум= 19,9 сая доллар	1157

Эх сурвалж: Алтбах, Ф., Салми, Ж (2011) “Судалгааны төгөлдөршилд хүрэх арга зам: Дэлхийн түвшний судалгааны их сургууль байгуулах нь”, ШУТИС, МУИС-ийн 2019 оны үндсэн үзүүлэлтүүд

ШУТИС, МУИС–ийн 1 багшид ногдох оюутны тооны үзүүлэлт судалгааны их сургуулиудынхтай ойролцоо хэдий ч 1 оюутанд ногдох зардлын үзүүлэлт нэн доогуур (2.5-60 дахин) байна.

Хүснэгт 2. Их сургуулиудын санхүүгийн үзүүлэлтүүд

Их сургуулиуд	Засгийн газрын төсөв	Оюутны төлбөр	Хандив, корпорацийн дэмжлэг	Өрсөлдөөнт судалгааны санхүүжилт	Зөвлөхүүд, сургалт, гэрээт судалгаа
Жяо Тун ИС	40	10	5	15	30
Пуханы ИС	6	7	34	45	6
Малайн ИС	73	11	10		6
Ибаданы ИС	85	1	1	2	10
Чилийн ИС	11	23	1	20	45
Чилийн Католик санваартны ИС	11	30	7	4	48
Бомбейн Технологийн институт	70	5	5	5	10
Хонконгийн ШУТИС	63	18	6	10	3
Монтеррей ИС		77	13	3	7
ЭЗДС	52	25	3	10	10
МУИС	5,7	75	1		6
ШУТИС	2	65	1.5		7

Эх сурвалж: Алтбах, Ф., Салми, Ж. (2011) “Судалгааны төгөлдөршилд хүрэх арга зам: Дэлхийн түвшний судалгааны их сургууль байгуулах нь”, ШУТИС, МУИС-ийн 2019 оны санхүүгийн тайлан

ШУТИС, МУИС –ийн төсөвт оюутны сургалтын төлбөрийн эзлэх хувь дэлхийн түвшний их сургуулиудынхаас 2-3 дахин өндөр байгаа ба өрсөлдөөнт судалгааны санхүүжилт, гэрээт судалгаа зэрэг үзүүлэлтүүдийн эзлэх хувь хэмжээ нэлээд бага хувийг эзэлж байна. Мөн их сургуулиудын төсөвт Засгийн газрын санхүүжилтийн эзлэх хувь доогуур байна. Эндээс дүгнэхэд сургалтын төлбөрийн түвшин доогуур манай орны нөхцөлд оюутны төлбөр дээр суурилсан санхүүжилт нь их сургуулийн хөрөнгө оруулалт, сургалт, судалгааг санхүүжүүлэхэд хангалтгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Их сургуулиудын судалгаа шинжилгээний нэг чухал үзүүлэлт нь IF өндөртэй сэтгүүлүүдэд хэвлэгдсэн өгүүллийн тоо байдаг. 2016 онд Хятадын судлаачид 426000 судалгааны бүтээлийг хэвлүүлсэн нь Scopus-д бүртгэлтэй бүтээлийн 18.6%-ийг эзэлж байсан ба АНУ-ын судлаачид 409000 бүтээл хэвлүүлжээ. Энэтхэг улс энэ үзүүлэлтээрээ Японыг давсан бөгөөд хөгжиж байгаа улс орнуудын энэхүү үзүүлэлт өсөх хандлагатай байна [12]. Олон улсын хамгийн нэр хүнд бүхий шинжлэх ухааны мэдээллийн сан болох Web of Science-д бүртгэлтэй сэтгүүлүүдэд 2019 онд Монгол улсын судлаачид 483 бүтээл хэвлэгдсэн ба дараахь байгууллагын эрдэмтэн, судлаачид хамгийн олон өгүүлэл хэвлүүлсэн байна. Үүнд, МУИС 101, ШУА 92, АШУУИС 71, ШУТИС 35, ХААИС 18, МУБИС 9 [2]. Уг үзүүлэлтийг бусад улс орны зарим их сургуулиудын жишээн дээрхарьцуулан авч үзье. Нэг жилд дунджаар (1999-2009 онуудын) Малайн их сургууль 340, Хонконгийн ШУТИС 1040, Хонконгийн их сургууль 1870, Сингапурын үндэсний их сургууль 2860, Сөүлийн үндэсний их сургуулийн тус тус 3377 бүтээлүүд хэвлэгджээ. Судалгааны их

сургуулиудын эрдэмтэн судлаачдын бүтээлийн чансаа ямар түвшинд байдаг нь энэхүү харьцуулалтаас харагдаж байна.

ДНБ-ий Судалгаа ба хөгжилд (R&D) зарцуулж байгаа хувь хэмжээ нь тухайн улс шинжлэх ухааны хөгжилд хэр зэрэг ач холбогдол өгч байгааг тусган харуулдаг. 2018 оны байдлаар хамгийн өндөр үзүүлэлттэй улс орнууд нь Израиль 4.9%, БНСУ 4.5%, Тайвань 3.4%, АНУ 2.8% байсан бол Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын гишүүн орнуудынх 2.6%, дэлхийн улс орнуудын дундаж үзүүлэлт 2.3%, БНХАУ 2.2%, ОХУ 1%, Монгол улс 0.2% байна [13]. Үүнээс үзэхэд Монгол улсын үзүүлэлт дэлхийн дунджаас 11.5 дахин доогуур байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсад судалгааны их сургууль байгуулах талаар зохих түвшинд яригдаж төрөөс тодорхой шийдвэрүүд гаргажээ. Судалгааны их сургууль байгуулахтай холбоотой төрөөс хууль эрх зүйн дараахь баримт бичгүүдийг батлан гаргасан. Үүнд:

- 2016 онд баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд” 2025 онд 4-өөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг их сургуульд оруулах талаар зорилт тусгагдсан. /Жич: Энэ нь тодорхой нарийвчилсан хөтөлбөр төлөвлөгөөгүй, хугацааны хувьд биелэх боломжгүй зорилт байв/
- 2017 онд батлагдсан төрөөс Шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлогод судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэхэд санхүүжилт хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлнэ гэж заажээ.
- 2018 онд Судалгааны ИС-ийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлагдсан.

Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг 2019-2023 он хүртэл 4 жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлэх хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Судалгааны үр дүнг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх;

- Их сургуулийн засаглал, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох;

- Санхүүжилтийн оновчтой эх үүсвэрийг бий болгох, өрсөлдөөнт тэтгэлгийн хэлбэрүүдийг хэрэгжүүлэх;

- Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн орчин үеийн тэргүүлэх чиглэлээр ахисан түвшний сургалт, судалгааг хөгжүүлэх;

- Судалгаа боловсруулалт, инновацийн хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх, дэд бүтцийг сайжруулах замаар инновацийн эко системийг хөгжүүлэх

Ерөнхийдөө энэхүү хөтөлбөрийг судалгаанд суурилсан их сургуулиудыг хөгжүүлэх үндэс суурийг бүрдүүлэх утга агуулгатай гэж дүгнэж болохоор байна. Уг хөтөлбөрт тусгагдсан олон чухал зорилтуудыг санхүүжүүлэхэд их сургуулиудын нөөц бололцоо тун хязгаарлагдмал бөгөөд үүнд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай юм.

Дүгнэлт

Орчин үед судалгааны их сургуулиуд нь улс орнуудын боловсролын тогтолцооны оргилд байж шинэ мэдлэг бий болгох, дэлхийн түвшний мэргэжилтэн бэлтгэх, инновацийн хөгжлийн түүхээ нь болж байна. Дэлхийн олон улс орнууд тусгайлсан бодлого, үйл ажиллагаагаар дэлхийн шилдэг их сургуулийн тоонд багтах сургуулийг харьцангуй богино хугацаанд байгуулж байна. Үүнийг БНХАУ-ын жишээ бэлхэн харуулж байна. Дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн их сургуулиудын рейтинг тогтоодог 3 байгууллагын (QS World University Ranking, Times Higher Education, Academic Ranking of World Universities) аргачлалуудыг судалж үзэхэд нийт онооны 60-иас дээш нь (100 хүртэл) зөвхөн дэлхийн түвшний судалгаагаар дүгнэж үзэж байна.

Манай улсын их сургуулиудын хувьд нэг оюутанд ногдох зардлын үзүүлэлт нэн доогуур, IF-тай сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо, гадаад профессор багш, оюутнуудын тоо цөөн, өрсөлдөөнт судалгаа гэрээт ажлын санхүүжилт дэлхийн түвшний их сургуулиудынхаас ихээхэн доогуур байна. 2018 онд Засгийн газраас Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх хөтөлбөр баталсан нь цаг үеэ олсон шийдвэр боловч төслийн хэрэгжилтийн эхний үе дуусч байхад дорвитой үйл ажиллагаа хийгдээгүй байна. Цаашид төрөөс судалгаанд суурилсан их сургуулиудыг хөгжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

[1]. Алтбах, Ф., Салми, Ж. (2011) “Судалгааны төгөлдөршилд хүрэх арга зам: Дэлхийн түвшний судалгааны их сургууль байгуулах нь”

[2]. Батхүү, Ж., (2020) Шинжлэх ухааныг санхүүжүүлэх зарчмаа шинэчиле

[3]. Эцковиц, Х., (2011) MIT ба энтрепренер шинжлэх ухааны үүсэл хөгжил, УБ.

[4]. Монгол улсын Засгийн газрын тогтоол. (2018) Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

[5]. Altbach, Ph., (2009) The costs and benefits of world class universities. Academic 90 (1):20-23

[6]. Atkinson, R., Blanpied, W. (2011) Research Universities: Core of the US science and technology system. Technology in Society

[7]. A master plan for higher education in California 1960-1975.

[8]. Costa, D. C., ZHA, Q. (2020) Chinese Higher Education: The role of the economy and Projects 211/985 for system expansion

[9]. Guanzi, Sh., Building (2018) World-Class Universities in China: From the View of National Strategies

[10]. Nelson, I., London, R., Strobel, K. (2015) Reinventing the Role of the University Researcher.

<https://doi.org/10.3102/0013189X15570387>

[11]. Salmi, J., (2009) The challenge of establishing world class universities. World bank

[12]. Tollefson, J., (2018) China declared world's largest producer of scientific articles. Nature 553. doi: <https://doi.org/10.1038/d41586-018-00927-4>

[13]. World bank statistics (2018) Research and development expenditure (% of GDP) [14]. World University Ranking Methodologies Compared (2017)